

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 3 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

“Жирмэн сүлжээ” ХК-ийн хувьцааг үнэт
цаасны бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1 дэх хэсэг, Өвөрхангай аймгийн Сум дундын 1 дүгээр шүүхийн 2004 оны 1/07 тоот шийдвэрийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жирмэн сүлжээ” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан 116189 ширхэг хувьцааг Үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар (Х.Бум-Эрдэнэ), Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК (Р. Содхүү), Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжаас хасахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Т.Гандулам)-д тус тус зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавин ажиллахыг Үнэт цаасны газар (Х. Бум-Эрдэнэ), олон нийтэд өдөр тутмын 2-оос доошгүй хэвлэлээр 2 удаа хэвлэн мэдээлэхийг Тамгын газар (Н. Удаанжаргал)-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН